

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн тайлан
Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

2025 оны 12 дугаар сарын 02

Улаанбатаар хот

Д/д	Шийдвэрийн нэр, огноо	Зүйл, заалтын дугаар	Зүйл, заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан	Хэрэгжилт (Хэрэгжсэн/Хэрэгжээгүй/ХБ)	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хяналтаас хасах үндэслэл
ҮАБЗ-ийн зөвлөмж							
48	Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2019-12-31 Дугаар 2019_60/40	105	2.6.УБ хотын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, гэр хороолол, аймаг сумын төвүүдэд дэвшилтэт технологи бүхий хэсэгчилсэн, зардал багатай ариун цэврийн байгууламжуудын шийдлийг туршин нэвтрүүлж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах, холбогдох стандартыг мөрдүүлэх	Улаанбаатар хотын хуучин төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, Морингийн цэвэрлэх байгууламжийг 60000 м3/хоногоор өргөтгөлийг эхлүүлэхээр ТЭЗҮ, зураг төслийн ажлыг 2026 оны улс, нийслэлийн төсөвийн төсөлд тусгуулхаар санал өгсөн боловч шийдвэрлэгдээгүй байна. Улаанбаатар хотын шинэ цэвэрлэх байгууламж 2025 оны 7 дугаар сарын 23 өдрөөс туршилтын бохир ус хүлээн авч туршилт тохируулгын ажил хийгдэж байна. 2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр техникийн комисс ажилласан бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 5-ний өдөр улсын комисс ажиллах төлөвлөгөөтэй ажиллаж байна.		Улаанбаатар хотын Ус сувгийн Удирдах газар ОНӨААТҮГ	
		106	2.7.Усны хэмнэлттэй хэрэглээг төлөвлүүлж, ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх зохистой менежментийг явуулах, үйлдвэрлэлийн хаягдал бохир усыг дэвшилтэт технологиор цэвэрлэж дахин ашиглахыг бодлогоор дэмжих	Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдөр Төв цэвэрлэх байгууламжийн өнөөгийн байдал, шинэ цэвэрлэх байгууламжийн бүтээн байгуулалт сэдэвт уулзалтыг боловсруулах чиглэлийн 70 үйлдвэр болон эмнэлгийн төлөөллүүдийг оролцуулан зохион байгуулсан. Нийслэлийн засаг даргын тамгын газар, Ус сувгийн удирдах газар хамтран урьдчилан цэвэрлэх байгууламж ашиглалтад оруулах хугацааг тохирон 44 боловсруулах чиглэлийн үйлдвэртэй гэрээ байгуулсан. Гэрээ байгуулсан үйлдвэрүүдээс хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлтэй 42 ойролцоох иргэн аж ахуйн нэгжийн газрыг худалдан авах хүсэлтэй 13 байна. Цаашид хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлтэй үйлдвэрүүдэд зөвлөгөө өгөх шаардлагатай тулгарч байгаа тул энэ асуудлыг шийдвэрлүүлэхээр НЗДТГ-т албан бичиг илгээсэн.		Улаанбаатар хотын Ус сувгийн Удирдах газар ОНӨААТҮГ	

ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл

		111	<p>4.Улаанбаатар хотын төвлөрсөн ус хангамжийн дээд эх үүсвэрийн тэжээгдлийн муж, хамгаалалтын бүсэд баригдсан аялал жуулчлал, амралтын газруудыг бохир ус цэвэрлэх байгууламжтай болгож, хог хаягдал, бохирын усыг хатуу хянах.</p>	<p>ГЗБГЗЗЕГ-т албан бичгээр хүсэлт хүргүүлж, Дээд эх үүсвэрийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсэд нийт 497 эзэмшил газар давхцалтай байгаа талаарх судалгааг 2025 оны эхний 9 сарын байдлаар хүлээн авсан.(Төв аймгийн Эрдэнэ сумаас давхцалтай хязгаарлалтын бүсийн 49, Налайх дүүргээс давхцалтай хязгаарлалтын бүсийн 382, хориглолтын бүсийн 66, бүгд-448) Эх үүсвэрийн бүсийн дэглэмд хяналт тавих байгууллагуудад дээрх судалгааг хүргүүлж ажиллахаар төлөвлөж байна.</p>		<p>Улаанбаатар хотын Ус сувгийн Удирдах газар ОНӨААТҮГ</p>	
52	<p>Улаанбаатар хотын усны нөөцийг нэмэгдүүлэх, хүн амын ундны усны чанарыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2014-12-30 Дугаар 2014_71/40</p>	115	<p>2.Улаанбаатар хотын бохир усны төв цэвэрлэх байгууламжийг өргөтгөж, технологийн иж бүрэн шинэчлэл хийх, гарсан цэвэршүүлсэн ус, лагийг эргүүлэн ашиглах төсөл;</p>	<p>Шинэ төв цэвэрлэх байгууламжийн 33 нэр төрлийн барилгын угсралт 100%, тоног төхөөрөмжийн угсралт 90%-тай явагдаж байна. 2025 оны 7-р сараас 1-р биореакторт ус хүлээн авч туршилт тохируулгын ажил эхэлж насос станц, элс баригч, нарийн сараалж, анхдагч болон хоёрдогч тунгаагуур, биореактор, гүн цэвэрлэгээний тунгаагуурийг ажилд оруулсан. Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн туршилт, тохируулгын ажил 2025 оны 12-р сарын 01-нд эхэлсэн. Лаг хатаах, шатаах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулагдан батлагдсан. Төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр судалж байна.</p>		<p>Улаанбаатар хотын Ус сувгийн Удирдах газар ОНӨААТҮГ</p>	

ЗГ-ын албан даалгавар

227	<p>ЗАСГИЙН ГАЗРЫН 2024- 2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТУХАЙ 2025-03-06 Дугаар 2025_02</p>	475	<p>2.19. 2.19.саарал усны хэрэглээ, усны дахин ашиглалтыг нэмэгдүүлэхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт;</p>	<p>Урьдчилан цэвэрлэх байгууламж угсрах 70 үйлдвэрээр Нийслэлийн хяналт шалгалтын газар, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Мянганы сорилтын сантай хамтран 2 удаагийн давхардсан тоогоор 120 үйлдвэрт хяналт шалгалт хийсэн. Тус ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 03 дугаар сарын 03-ны едрийн 53 дугаар тогтоолоор Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө батлагдсантай холбогдуулан Монголын мянганы сорилтын сангаас бэлтгэн гаргасан Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усны стандарт. Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх технологиуд, хэрэглээ. Хүнсний үйлдвэрүүдэд зориулан гаргасан вебинаруудтай танилцан үйлдвэрт нэвтрүүлэх, MNS 6561:2024 Хүрээлэн буй орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлагуудыг хангасан хаягдал усыг гаргаж тогтоол, стандартуудын хэрэгжилтийг хангаж ажиллах талаарх мэдэгдэл хүргүүлсэн байна.</p>		<p>Улаанбаатар хотын Ус сувгийн Удирдах газар ОНӨААТҮГ</p>	
228	<p>ЗАСГИЙН ГАЗРЫН 2024- 2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАСТ ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2025-03-07 Дугаар 2025_03</p>	495	<p>1.16. 1.16. Саарал усны хэрэглээ, усны дахин ашиглалтыг нэмэгдүүлэх;</p>	<p>2025 оны 11 дүгээр сарын байдлаар нийслэлийн хэмжээнд манай байгууллагатай гэрээтэй 131 авто машин угаалга үйл ажиллагаа явуулдаг. Үүнээс ус дахин ашиглах тоног төхөөрөмжтэй суурилуулсан 29 авто машин угаалгын газар байна. Ус дахин ашиглах тоног төхөөрөмж шинээр нэмэгдүүлэх 24 авто машин угаалгад албан шаардлага өгч ажилласан.</p>		<p>Улаанбаатар хотын Ус сувгийн Удирдах газар ОНӨААТҮГ</p>	